



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 8/01

Баян-Өндөр сум

Нийгмийн бодлогын мэргэжилтэн А.Нэргүйг
шилжүүлэн ажиллуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5, 44.1, Монгол Улсын Их хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.5, 2.10, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 489 дүгээр тогтоолын 5 дахь заалт, 491 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн бодлогын мэргэжилтэн А.Нэргүйг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөр үндсэн ажлаас нь дуусгавар болгон чөлөөлж 2023 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс эхлэн Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэнээр шилжүүлэн томилсугай.

2. А.Нэргүйгийн үндсэн цалинг ТЗ-9 дахь шатлал 791532 (долоон зуун ерэн нэгэн мянга таван зуун гучин хоёр) төгрөг, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл үндсэн цалингийн 25 хувиар, зэрэг дэвийн нэмэгдэл 16 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч (Ц.Долгормаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.СОНИНБАЯР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 8/02

Баян-Өндөр сум

А.Нэргүйг түр орлон гүйцэтгэгчээр
томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.9, 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн бодлогын мэргэжилтэн өөр ажилд шилжсэн тул Хөдөө аж ахуйн тасгийн мал аж ахуй хариуцсан мэргэжилтэн А.Нэргүйгээр түр орлон гүйцэтгүүлсүгэй.

2. А.Нэргүйд түр орлон гүйцэтгэж буй албан тушаалын цалингийн 40 хувиар тооцож 2023 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг нягтлан бодогч (Ц.Долгормаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.СОНИНБАЯР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар Б/03

Баян-Өндөр сум

Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.3, 83 дугаар зүйлийн 83.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн мэргэжилтэнг түр орлон гүйцэтгэгч Баярхүү овогтой Баасанхүүг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ажлаас чөлөөлсүгэй.

2. Б.Баасанхүүтэй хөрөнгө санхүүгийн болон амралтын тооцоо хийж дуусгахыг нягтлан бодогч (Ц.Долгормаа)-д даалгасугай.

ДАРГА



Д.СОНИНБАЯР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 6/04

Баян-Өндөр сум

Ажилд томилох тухай

Монгол Улсын хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 489 дүгээр тогтоолын 5 дахь заалт, Засгийн газрын 491 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн мэргэжилтэн Ш.Цэрэнсугарын хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусгавар болж ажилд орох хүсэлтээ ирүүлсэн тул 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үндсэн ажилд нь томилсугай.

2. Ш.Цэрэнсугарын үндсэн цалинг ТЗ-9 дахь шатлал 791532 (долоон зуун ерөн нэгэн мянга таван зуун гучин хоёр) төгрөг, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл үндсэн цалингийн 13 хувиар, орон нутгийн нэмэгдэл 40 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Ц.Долгормаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.СОНИНБАЯР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 5/05

Баян-Өндөр сум

Галын аюулгүй байдлыг хариуцсан
ажилтан томилох тухай

Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.2, 17.2.9, 17.2.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын галын аюулгүй байдлыг хариуцсан ажилтанаар Хөдөө аж ахуй тасгийн мал үржил хариуцсан мэргэжилтэн (А.Нэргүй)-г томилсугай.

2. Галын аюулгүй байдлын дүрэм, гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулан батлуулах, галын аюулгүй байдлыг хариуцан хангах, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт суулган батлуулах, ажилтан албан хаагчдыг гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах арга ажиллагаанд сургах, гал түймрийн аюулын үнэлгээг хийлгэх, галын дүгнэлт гаргах ажлыг галын аюулгүй байдал хариуцсан ажилтан (А.Нэргүй)-д даалгасугай.

3. Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн батлуулж холбогдох албан тушаалтанд хянуулж, жил бүр тодотгол хийж ажиллахыг (А.Нэргүй)-д даалгасугай.

ДАРГА



Д.СОНИНБАЯР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар Б/06

Баян-Өндөр сум

Номхүү овогтой Дэлгэрбатыг няравын
ажлаас түр чөлөөлөх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2,
Байгууллагын дотоод журмын 7.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын нярав ажилтай Н.Дэлгэрбат нь 6 сарын
хугацаатай чөлөө авах хүсэлтээ ирүүлсэн тул 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс
эхлэн үндсэн ажлаас түр чөлөөлсүгэй.

2. Н.Дэлгэрбаттай хөрөнгө санхүүгийн болон ээлжийн амралтын тооцоо хийж
дуусгахыг нягтлан бодогч (Ц.Долгормаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.СОНИНБАЯР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар Б/07

Баян-Өндөр сум

Н.Баасанжаргалыг түр томилох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.4, Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын нярав Н.Дэлгэрбат нь чөлөө авсан тул Засаг даргын Тамгын газрын няравын албан тушаалд Наранхүү овогтой Баасанжаргалыг 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс чөлөөний хугацааг дуусах хүртэл түр хугацаагаар томилон ажиллуулсугай.

2. Нярав Н. Баасанжаргалыг ТҮ-4 дэх шатлал 638212 (зургаан зуун гучин найман мянга хоёр зуун арван хоёр) төгрөгөөр цалинжуулахыг нягтлан бодогч (Ц.Долгормаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.СОНИНБАЯР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар Б/08

Баян-Өндөр сум

С.Золбаярыг Нийгмийн бодлогын
мэргэжилтнээр томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 27 дугаар зүйлийн 27.3, Төрийн албаны салбар зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 51 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 489 дүгээр тогтоолын 5 дахь заалт, 491 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтнээр Сэр-Од овогтой Золбаярыг 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. С.Золбаярын үндсэн цалинг ТЗ-9 дэх шатлал 791532 (долоон зуун ерэн нэгэн мянга таван зуун гучин хоёр) төгрөг, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 3 хувиар, орон нутгийн нэмэгдэл 40 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Ц.Долгормаа)-д зөвшөөрсүгэй.

3. Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/02 дугаар тушаалыг 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

ДАРГА



Д.СОНИНБАЯР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 04 өдөр

Дугаар Б/09

Баян-Өндөр сум

Наранхүү овогтой Баасанжаргалыг няравын т
ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.9 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын няравын ажилд түр хугацаагаар ажиллаж байсан Н.Баасанжаргалыг 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөр тасалбар болгон үндсэн ажлаас чөлөөлсүгэй.

2. Н.Баасанжаргалтай хөрөнгө санхүүгийн тооцоо хийж дуусгахыг нягтлан бодогч (Ц.Долгормаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.СОНИНБАЯР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 07 өдөр

Дугаар Б/10

Баян-Өндөр сум

Н.Дэлгэрбатыг ажилд томилох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.12, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын нярав Номхүү овогтой Дэлгэрбатыг 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Нярав Н.Дэлгэрбатыг ТҮ-4 дэх шатлал 868000 (найман зуун жаран найман) төгрөг, ур чадварын нэмэгдэл 20 хувиар бодож цалинжуулахыг нягтлан бодогч (Ц.Долгормаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.СОНИНБАЯР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар Б/11

Баян-Өндөр сум

Засаг даргын Тамгын газрын
Үйлчлэгч Н.Хишигдуламыг ажлаас
чөлөөлөх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.9, Тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Засаг даргын Тамгын газрын үйлчлэгч Н.Хишигдулам нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан тул 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн ажлаас чөлөөлсүгэй.

2. Н.Хишигдуламтай хөрөнгө санхүүгийн тооцоо хийж дуусгахыг нягтлан бодогч (Ц.Долгормаа)-д даалгасугай.

ДАРГА



Д.СОНИНБАЯР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 5/12

Баян-Өндөр сум

Н.Хишигдуламыг ажилд түр томилох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 145 дугаар зүйлийн 145.1, Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралт, 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, 2022 оны 491 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Н.Хишигдуламыг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн Засаг даргын Тамгын газрын үйлчлэгчийн ажилд түр томилсугай.

2. Н.Хишигдуламын үндсэн цалинг ТҮ-1 шатлал 750.000 (долоон зуун тавин мянган) төгрөг, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 21 хувиар, ур чадварын нэмэгдэл 20 хувиар тус тус бодож олгохыг нягтлан бодогч (Ц.Долгормаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.СОНИНБАЯР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар Б/13

Баян-Өндөр сум

Засаг даргын Тамгын газрын
Үйлчлэгч Н.Хишигдуламыг ажлаас
чөлөөлөх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.9, Тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Засаг даргын Тамгын газрын үйлчлэгч Н.Хишигдулам нь байгууллагын удирдлагатай харилцан тохиролцож түр хугацаагаар ажиллаж байсан тул 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөр дуусгавар болгон ажлаас чөлөөлсүгэй

2. Н.Хишигдуламтай хөрөнгө санхүүгийн тооцоо хийж дуусгахыг нягтлан бодогч (Ц.Долгормаа)-д даалгасугай.

ДАРГА



Д.СОНИНБАЯР